



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/60

Булган сум

Гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Монголын баялаг-330” төсөл хөтөлбөрийн хүрээнд Булган аймгийн байгалийн үзэсгэлэнт газрууд болон түүхийн дурсгалт газруудыг бүртгэн баримтжуулах, архивлах ажлын гэрээг 73,194,000 (далан гурван сая нэг зуун ерэн дөрвөн мянга) төгрөгт багтаан хууль, журмын дагуу зохион байгуулан, чанарын болон хугацааны хяналт тавьж ажиллах эрхийг Соёл, урлагийн газрын дарга (Г.Алдармөнх)-д олгосугай.

2.Гэрээнд заасан ажил үйлчилгээг холбогдох хууль, журам, стандартын дагуу хийж гүйцэтгэхийг “Монгол баялаг өв соёл” ХХК (Г.Хишигжаргал)-д даалгасугай.

3.Ажил үйлчилгээг гүйцэтгэх явцад мэргэжлийн зөвлөгөө өгч, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг)-т даалгасугай.

4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Sugar Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж

6330011200